

**“ХӨГЖЛИЙН ЗОРИЛТОТ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ” УЛСЫН
ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 10 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 7 дугаар сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь тогтоолыг төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасны дагуу Монгол Улсын Үндсэн хууль болон Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийцүүлэн боловсруулж, өргөн мэдүүлсэн байна.

Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлагдснаар 2030 онд эдийн засгийн жилийн дундаж өсөлтийг 6 хувьд хадгалах, хүний хөгжлийн индекс болон дундаж наслалтыг нэмэгдүүлэх, ядуурлын түвшинг бууруулах, засаглалын үр нөлөөний үзүүлэлтийг өсгөх, үндэсний өрсөлдөх чадварын индексээр дэлхийд эзлэх эрэмбийг урагшлуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх зэрэг эдийн засаг, нийгмийн таатай нөхцөл үүснэ гэж төсөл санаачлагч үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг Засгийн газар хөгжлийн зорилтот хөтөлбөр зайлшгүй байх хэрэгтэй гэж үзвэл тогтоолын төслийг буцаан татаж, хэмжих нэгж, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, суурь түвшинг нь тодорхой болгон оруулж ирэх, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг тогтоолын төсөлд салбар хоорондын уялдаа холбоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилтай, орлоготой иргэн байх талаарх тооцоо судалгаа, статистик мэдээ хангалтгүй, хөгжлийн бодлогын гол цөм нь хүний хөгжлийн индекс рүү чиглэх, хөдөлмөрт зуучлах, ажлын байрны хүртээмжийг дээшлүүлэх, ажлын үр дүнг бодитоор үнэлэх, дүгнэх талаар тусгагдаагүйг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ Эдийн засаг, хөгжлийн яам нь Монгол Улсын хөгжлийг макро түвшинд төлөвлөдөг байх, баримт бичиг боловсруулалтын хэмжээнд шаардлага хангасан боловч хэрэгжих боломжгүй арга хэмжээнүүдийг төлөвлөсөн, эдийн засгийн баталгаа, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, ядуурлыг бууруулах талаар тусгагдаагүйг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр хөгжлийн төлөвлөгөө багадаагүйг онцолж, төлөвлөгөөний хэрэгжилтийг 5 жилд биш жил бүр тайлагнадаг байх, төлөвлөгөөнд ажлын байрыг нэмэгдүүлэх, гадаад уруу хөдөлмөр эрхлэх, эмчлүүлэхээр явах иргэдийн урсгалыг багасгах, эмнэлэгийн оношилгоог дотооддоо оношлох, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд яам тус бүрийн төлөвлөгөөнүүдийг нэгтгэж, ач холбогдлоор нь эрэмбэлэн, эдийн засгийн оновчтой төлөвлөлт хийх, урт хугацааны тогтвортой бодлоготой байх, Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-т Хөгжлийн зорилтот хөтөлбөр батална гэж

байгаа тул ажлын хэсэг байгуулан, цаашид сайжруулаад явах, Эдийн засаг, хөгжлийн яам бодлогын баримт бичиг хоорондын уялдааг хангахад анхаарах зэрэг санал хэлсэн болно.


Байнгын хорооны хуралдаанаар хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Хөгжлийн зорилтот хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Ц.ЦЭРЭНПУНЦАГ